

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Ответственный редактор:	Академик С.Чулуун
Научные редакторы:	доктор филол. наук И.В.Кульганек Ph.D Н.Хишигт
Редакторы, составители:	Ph.D Б.Нацагдорж канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Managing Editor:	Academician S.Chuluun
Scientific Editors:	Dr.Sc. (Philology) I.V.Kulganek Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler:	Ph.D (History) B.Natsagdorj Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгорсүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дыргеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социоллингвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

Д.А.Носов

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках
по Монголии 1923—1925 гг. 149

К.В.Орлова

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов 160

Р.Ю.Почекаев

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» 167

Г.Сэр-Од

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг 176

М.В.Федорова

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.
в собрании Российского этнографического музея, как источник
для изучения традиционной культуры монголов 186

Ц.Цэрэндорж

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд
холбогдох мэдээ баримтаас 204

Д.Энхцэцэг

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай 219

Ц.Энхчимэг

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн
чухал сурвалж болох нь 240

Н.С.Яхонтова

Аспиранты из Монголии в Академии наук 250

Сведения об авторах 268

Зохиогчдын танилцуулга 272

Ц.Цэрэндорж

**XV-XVIII ЗУУНЫ СОЛОНГОС СУРВАЛЖ ДАХЬ
МОНГОЛЫН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ МЭДЭЭ БАРИМТААС
- “Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл” -**

DOI 10.25882/kpcc-xt23

XVI зууны эцсээр Цзяньчжоу-гийн Зүрчидийн нэгэн толгойлогч Нурхачи хүчирхэгжин Зүрчидийн бусад аймгуудыг нэгтгэж, хөри зэргэлдээх улсуудын талаар дайсагнасан бодлого явуулах болсон юм. Амнок (Ялу) мөрөн орчмын зүрчид аймгуудыг эрхшээлдээ оруулсны дараа Нурхачи Солонгосын Чосөн улстай найрамдалт харилцаа тогтоохыг оролдов. Мин улсын талыг тууштай баримтлагч Чосөн улс анхандаа Нурхачитай холбоо тогтоохоос зайлсхийж байлаа. Гэвч Нурхачи Чосөн улсын олзлогдогсдыг тус улсад буцаан илгээсэн тул Чосөний тал ч түүнд эерэгээр хандахаас өөр аргагүй болж, үүний хариуд Шинь Чхүн-ил (신충일, 申忠一)-ийг 1596 онд элч болгон илгээсэн юм. Шинь Чхүн-ил Зүрчидэд үзэж харсан зүйлдээ тулгуурлан “Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл (건주기정도기, 建州紀程圖記)” хэмээх айлтгалыг зохион Чосөн улсын ванд өргөн барьсан билээ. Тус тэмдэглэл нь Зүрчидийн газар нутаг, уул ус, хот суурин, хүн ам, цэрэг арми, улс төр, зан заншил зэрэг олон талыг хамарсан нарийн мэдээллийг агуулдаг. Шинь Чхүн-илийн тэмдэглэл 90 гаруй зүйлд хуваагддаг агаад түүний дотор Монголтой холбоотой мэдээ баримт байдаг.

Түлхүүр үг: Монгол, Солонгос, сурвалж, “Чосөн улсын магад тэмдэглэл”, Шинь Чхүн-ил, “Цзяньчжоу”-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл.

Tserendorj Tsegmediin

**A STUDY ON DOCUMENTS RELATED TO 14TH-18TH
CENTURIES MONGOLIA IN HISTORICAL SOURCES OF KOREA –
FOCUSING ON THE “GEONJU (JIANZHOU) GIJUNG DOGI
(建州紀程圖記)” BY SHIN CHUNGIL (申忠一)**

At the end of the 16th century, Nurhaci, one of the leaders of the Jianzhou Jurchen unified the Jurchen tribes and executed a hostile policy towards

neighboring countries. After taking control over the Jurchen tribes along the Yalu River, Nurhaci attempted to negotiate with Joseon. However, Joseon government, minding the Ming China, tried to refuse the negotiation. Yet Joseon government had no choice but to take positive attitude toward Nurhaci, since he sent back captives to Joseon along with the letter. Joseon government decided to send Shin Chungil as a reply. After his return, Shin Chungil submitted a report based on his own information which he observed and acquired during the visit. This report, entitled as “Geonju (Jianzhou) gijung dogi (建州紀程圖記)”, contained a map and detailed information about the territory, mountains, towns, population, army, politics, and customs of the Jianzhou Jurchen. The report is divided into more than 90 items, including information about the Mongols.

Key words: *Mongolia, Korea, “Veritable Records of the Joseon Dynasty”, Shin Chungil, “Geonju (Jianzhou) gijung dogi”.*

Оршил

Монголын эрт, дундад үеийн түүхийн судалгаанд тулгардаг бэрхшээлийн нэг бол сурвалж хэрэглэгдэхүүн харьцангуй хомс байдаг явдал билээ. Аз болоход, манай түүхэнд холбогдох мэдээ занги хөрш зэргэлдээ Хятад, Солонгос зэрэг орны түүхийн сурвалжид багагүй хэмжээгээр үлдэж хоцорчээ. Солонгосын түүхийн сурвалжийн дотор Монголын түүхэнд холбогдох арвин мэдээ баримт агуулж буй нь гэвэл “Гурван улсын түүхэн тэмдэглэл (сол. 삼국사기, нан. 三國史記)”, “Гурван улсын нөхсөн судар (сол. 삼국유사, нан. 三國遺事)”, “Пархэгийн шинжлэл (сол. 발해고, нан. 渤海考)”, “Зүүн гүрний цэргийн толь (сол. 동국병감, нан. 東國兵鑑)”, “Корйө (Гуулин) улсын судар (сол. 고려사, нан. 高麗史)”, “Корйө (Гуулин) улсын судрын чухал анги (сол. 고려사절요, нан. 高麗史節要)”, “Чосөнъ улсын магад тэмдэглэл (сол. 조선왕조실록, нан. 朝鮮王朝實錄)”¹, Мин улс хийгээд Манж Чин улсад зорчсон Чосөнъ улсын элч нарын аян замын тэмдэглэлүүд зэрэг болой.

Монгол улсад “Корйө (Гуулин) улсын судар” гэх мэт Корйө-гийн үеийн сурвалжийг харьцангуй их судалсан агаад эдүгээ түүнээс арай хожуу үеийн, өөрөөр хэлбэл Чосөнъ улсын үеийн түүх тэмдэглэл дэх Монгол лугаа хамаа бүхий баримт хэрэглэгдэхүүнийг судалж эхлээд

¹ Хятадаар “шилү (實錄)” хэмээх үгийг Манжийн түүх бичигт “үнэн магад хууль”, “магад хууль” хэмээн орчуулж хэвшсэн боловч, өнөөгийн хууль хэмээх ойлголттой андуурч болзошгүй тул ханз үсгийн утгыг баримтлан “магад тэмдэглэл” хэмээн орчуулав.

байна. Миний бие урьд нь Чосөнъ улс (1392-1910)-ын вангуудын өдөр тутмын хэрэг явдлыг тэмдэглэсэн “Чосөнъ улсын магад тэмдэглэл (조선왕조실록, 朝鮮王朝實錄)”² хэмээх асар том хэмжээний он дарааллын бичиг дэх Монголын түүхэнд холбогдох мэдээ баримтыг танилцуулж³ байсан билээ. Харин энэ удаа түүнд тэмдэглэгдэн үлдсэн Чосөнъ улсын түшмэл Шинъ Чхүн-илийн аяны тэмдэглэл дэх Монголтой холбоотой мэдээ баримтыг танилцуулъя.

Нэг. “Чосөнъ улсын магад тэмдэглэл” дэх Монголын түүхэнд холбогдох мэдээ баримтын тойм

“Чосөнъ улсын магад тэмдэглэл”-ийн бүр эхнээс Монголтой холбоотой мэдээ баримт гарах агаад энэ нь тус улсыг үндэслэн байгуулагч И Сөнге-гийн дээд удам Монголын харьяат байсан, И Сөнге ч бас Юань улсын эцсийн улиралд монголчуудтай дайн тулаан хийж байсан зэрэг түүхэн нөхцөл байдалтай холбоотой билээ.

Тус сурвалжид Монголыг нэрлэн заахдаа “Монгол” (сол. 몽고, нан. 蒙古 menggu) гэдгээс гадна Татар (сол. 달달, нан. 達達 dada), Татар (сол. 달달, нан. 韃靼 dada), Умард Юань (сол. 복원, нан. 北元 bel yuan), Татар хулгай (сол. 달적, нан. 達賊 dazei), Дацзы (сол. 달자, нан. 達子 dazi), Тацзы (сол. 달자, нан. 獐子 tazi), Умардын хулгай (сол. 복로, нан. 北虜 bei lu) зэрэг нэр томьёог хэрэглэж байжээ.

Түүнчлэн монголын тусгай аймгуудыг, тухайлбал Ойрадыг Вала

² “Чосөнъ улсын магад тэмдэглэл (сол. 조선왕조실록, нан. 朝鮮王朝實錄)” нь тус улсыг үндэслэгч Тэжо (сол. 태조, нан. 太祖) И Сөнге (1392-1398)-гээс Чхөлжон (сол. 철종, нан. 哲宗) ван (1849-1863) хүртэлх Чосөнъ улсын 25 вангийн өдөр тутмын хэрэг явдлыг он, сар, өдрийн дарааллын дагуу тэмдэглэсэн асар том хэмжээтэй сурвалж юм. Нийт 1894 боть, 888 дэвтрээс бүрдэх бөгөөд 1997 онд ЮНЕСКО-гийн дэлхийн соёлын өвд бүртгэгджээ. “Магад тэмдэглэл” нь: сударч түшмэл вангийн дэргэд байж түүний өдөр тутмын үйл хэргийг нэгд нэгэнгүй тэмдэглэдэг байсан, тухайн ван өөрийн хэрэг явдлыг бичиж буй сударч түшмэлийн тэмдэглэлийг үзэх эрхгүй, тухайн ванг нас барсны дараа энэхүү тэмдэглэл болон бусад баримтад тулгуурлан “Магад тэмдэглэл”-ийг найруулан бичдэг гэх зэрэг онцлогтой ажээ.

³ Ц.Цэрэндорж, Монголын Тайсун хаанаас 1442 онд Чосөнъ улсын Сэжон ванд илгээсэн сургах зарлигийн бичиг - Түүхийн судлал, Том. 40, УБ. 2010; Ц.Цэрэндорж, Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн зарим мэдээ – CNEAS Reports 13, Чин улс ба монголчууд, Япон, Сэндай, 2014; Ц.Цэрэндорж, Солонгосын түүхийн сурвалж дахь XIV-XVIII зууны үеийн Монголтой холбоотой мэдээ баримт - “Солонгос судлал” сэтгүүл, 1 (5), 2018, 10-26-р тал; Ц.Цэрэндорж, Солонгосын түүхийн сурвалж дахь XIV-XVIII зууны үеийн монголтой холбоотой мэдээ баримт (“Чосөнъ улсын магад тэмдэглэл”-ийн жишээн дээр) - “Түүхийн судлал”, №48, УБ. 2019, 92-104-р тал.

(сол. 와라, **нан.** 瓦剌 wala), Урианхайг Улянха (сол. 올랑합, **нан.** 兀良哈 wuliangha), Гурван харуулын тацзы (сол. 삼위달자, **нан.** 三衛獐子 sanwei tazi) гэх зэргээр ялгаварлан нэрлэж байсан нь Чосөн-ий эхэн үед Монголын талаар багагүй мэдлэгтэй байсныг харуулдаг.

Харин XVII зууны үеэс эхлэн Баруун Татар (сол. 서달, **нан.** 西獐 hita), Тайцзи Татар (сол. 태극달자, **нан.** 太極獐子 taiji tazi, Даюань Татар (сол. 대원달자, **нан.** 大元獐子 dayuan tazi), Тадань (сол. 달단, **нан.** 獐旦 tadan), Алудэй (сол. 아로득, **нан.** 阿魯得 aludei) гэх зэрэг нэрээр нэрлэх болжээ. Эдгээрийн дотроос Баруун Татар гэдэг нь цаг үеэсээ хамааран Монголын өөр өөр хэсгийг зааж байсан гэлтэй.

Бид “Чосөн-ий улсын магад тэмдэглэл”-ээс дээр дурдсан янз бүрийн нэрээр хайж үзсэний үр дүнд Монголтой холбоотой 415 зурвас мэдээг илрүүлэв. Тэдгээр мэдээ баримтыг

1. Тухайн үед өрнөсөн хэрэг явдлын талаарх мэдээ
2. Хэдүйн болж өнгөрсөн түүхэн үйл явдлыг нэхэн өгүүлсэн


гэсэн 2 үндсэн хэсэгт ангилж болно.

1. Болж өнгөрсөн түүхэн үйл явдал

Энэ ангилалд нийт 48 үйл явдал буюу зурвас мэдээ багтах агаад үүнээс гадна Газарзүйн ойллогод нийт 10 хэсэг газарт Монголтой холбоотой мэдээ гарч байна. Дээрх 48 мэдээг агуулгаар нь ангилбал дараах байдалтай ажээ. Үүнд:

- Монголчууд Корйө-г довтолсон тухай, Корйө-гийн үеийн үйл явдал
- Их Монгол улс, Юань улсын үеийн үйл явдал
- Хүннүгийн тухай
- Хубилайн тухай
- Эсэн Мин улсын хуандиг олзолсон тухай
- Чосөн-ий үеийн үйл явдал
- Тогто чэнсянгийн тухай
- Солонгост үлдсэн монгол уламжлал
- Сун улс-Корйөгийн харилцаа
- Галт буу анх Монголын үед дэлгэрч байсан тухай
- Түмэдийн Алтан ханы тухай

Эдгээр мэдээ баримтыг доорх хүснэгтэд “Чосөн-ий улсын магад тэмдэглэл”-д гарч буй он цагаар нь ангилан үзүүлэв.



Хүснэгт 1. Болж өнгөрсөн түүхэн үйл явдлыг тэмдэглэсэн мэдээний он цагийн ангилал

1. Тухайн үед өрнөсөн хэрэг явдлын талаарх мэдээ


Хэрэг явдлыг тухайн үед нь тэмдэглэн үлдээсэн 367 зурвас мэдээ байгааг олж илрүүлсэн бөгөөд тэдгээрийг агуулгаар нь ангилбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Мэдээг агуулгаар нь ангилсан нь


Ангилал	Нарийвчилсан агуулга	
Монгол-Солонгосын харилцаа	Монгол-Корйө-гийн харилцаа, И Сөнгө болон түүний өвөг дээдсийн үйл ажиллагаа	7
	Монгол-Чосөнь-ий харилцаа	3
	Урианхай нар Чосөнь-тэй харилцсан, алба барьсан, тэдний талаар явуулах бодлого	4
	Татарууд Чосөнь-ийг довтолно гэсэн сураг чимээ	3
	Чосөнь улс Татарын довтолгооноос сэргийлэхийн тулд авсан арга хэмжээ, санал	38
	Эсэнгийн довтолгооны Чосөнь-д үзүүлсэн нөлөө	3
	Татарууд (Урианхайн харуул) Чосөнь-ийг довтолно гэсэн мэдээ	2
	Эсэнгийн тухай мэдээ	4
	Монголын довтолгооны тухай Чосөнь-ий түшмэлийн айлтгал, санал	7
	Монголын байдлыг тагнах, хэл чимээ олж ирэх тухай	3
	Манжийн үеийн Монгол-Чосөнь-ий худалдаа	2

	Монгол хэлний сургалт, хэлмэрч түшмэл	18
	Монгол хэл мэддэг хүмүүсийн тухай	4
	Чосөнъ-Манжийн дайнд оролцсон монгол цэргийн үйл ажиллагаа	16
	Чосөнъ улсад элчээр ирсэн монгол хүн	1
	Солонгос дахь татар, хвачөг нарын тухай	3
Монгол-Мин улсын харилцаа	Монгол-Мин улсын харилцаа	13
	Монгол-Мин улсын дайн тулалдаан	28
	Монголын цэргийн үйл ажиллагаа	10
	Монголын эсрэг цэрэг дайны арга бодлого	1
	Мин улс дахь татаруудын үйл ажиллагаа	2
Монгол-Манжийн харилцаа	Зүрчид-Монголын харилцааны тухай	9
	Монгол-Манжийн харилцаа	10
	Монгол-Манжийн дайн тулалдаан	8
	Ойрад-Манжийн дайн тулалдаан	9
	Баруун Татар (Халх?, Ойрад)-Манжийн харилцаа	4
	Манжийн эсрэг монголчуудын гаргасан бослого	10
	Манжийн эрхшээлийн үеийн монгол ноёд-Манжийн харилцаа	5
	Монгол-Мин улс-Манжийн харилцаа: Мин улсыг дайлахад оролцсон монгол цэрэг	10
Чосөнъ-Мин улсын харилцаа	Мин улс-Чосөнъ-ий харилцаа, элч илгээх (Монголтой холбоотой нь)	5
	Татарыг довтлохын тулд Мин улс Чосөнъ-өөс цэргийн тусламж хүссэн тухай	1
	Татараас зайлж Чосөнъ-д ирсэн хүмүүсийн тухай	4
	Чосөнъ улс Татарт тусална гэж Мин улс сонссон тухай	1
Монголын соёл	Монгол соёл, хувцас, бичиг үсэг, зэр зэвсэг, угсаа гарлын тухай	6
	Монгол ном, сурах бичиг	4
	Чосөнъ улсын Са-йөгвөнъ дэх монгол хэлний сургалт	12
	Монгол бичгээр бичсэн захидал, тамга, хөшөө, харилцсан бичиг	10
(Манжийн үеийн) монголчуудын зан суртлын тухай		3

(Манжийн үеийн) монголчуудын шашин шүтлэгийн тухай		3
Монголын газарзүй	Татартай зах нийлдэг, тэдэнтэй ойролцоо нутагладаг тухай	7
Монгол мал, амьтны тухай		6
Монголын улс төрийн байдал	Монголын дотоод улс төрийн байдлын тухай мэдээ	6
	Урианхайн тухай мэдээ	8
	Баруун Татар (Ойрад)-ын улс төрийн байдлын тухай	3
	Монголын байдлын талаарх чосөнъ түшмэдийн санал, үзэл бодол	4
	(Манжийн үеийн) Монголын улс төрийн байдлын тухай	10
	Манжийн харьяан дахь монгол ноёд	5
	(Манжийн үеийн) монголчууд дахин Дундад улсыг эзлэх тухай Чосөнъ-ий ван, түшмэдийн үзэл бодол	2



Хүснэгт 3. Тухайн үед өрнөсөн хэрэг явдлыг гарч буй он цагаар ангилсан нь



Хүснэгт 4. Тухайн үед өрнөсөн хэрэг явдлыг зуунаар ангилсан нь

Дээрх хүснэгтээс харахад Монголтой холбоотой мэдээ 1409-10 оны үед ихэсч ирсэн бөгөөд энэ нь тухайн үед өрнөсөн Монгол-Мин улсын дайн тулаан буюу Мин улсын Юнлэ хуанди Монголыг 5 удаа довтолсонтой холбоотой болох нь мэдээний агуулгаас тодорхой харагдаж байна.

Түүнээс хойш 1440-50-аад онд хамгийн их буюу нийт мэдээний 4-ний 1-т хүрсэн ажээ. Түүний шалтгаан нь 1440-өөд оны эхэн үеэс Монголын засгийн газар Чосөнъ улсыг талдаа татах бодлого явуулж эхэлсэн, 1447 онд монголчууд Чосөнъ-ий умард хил хүртэл довтолж магадгүй гэсэн цуурхал тархсаны улмаас Чосөнъ-ий тал монголчуудын байлдааны үйл ажиллагааны талаар мэдээ цуглуулж, хил хязгаарын хамгаалалтаа чангатгасан, 1449 онд монголчууд Мин улсын эзэн хааныг олзолсон “Туму-гийн хэрэг явдал”-аас улбаалан Чосөнъ улсын гадаад байдлыг нэн түгшүүртэй болсон, Монголын цэрэг Чосөнъ улсыг довтолсон тохиолдолд авах арга хэмжээг Чосөнъ улсын засгийн газар хэлэлцсэн зэрэг үйл явдалтай холбоотой юм. Өөрөөр хэлбэл, 1440-1450-аад онд Чосөнъ-ий засгийн газар Мин улсыг түлхэн унагааж болзошгүй хүч бол Монгол хэмээн үзэж, Монголын талаар мэдээ мэдээлэл идэвхтэй цуглуулж, тэднийг довтлон ирвэл хэрхэх тухай арга бодлого боловсруулж, бэлтгэж байсан нь энэ үед Монголтой холбоотой мэдээ баримт ихэссэний шалтгаан болой.

Түүний дараа 1590-ээд оны үеэс эхлэн Монголын талаарх мэдээ дахин ихэссэн нь 1590-ээд оноос Цзяньчжоу-гийн Зүрчид хүчирхэгжиж, Монголын талаар идэвхтэй бодлого явуулсантай холбоотой. Улмаар 1627, 1636 онд манж нар Чосөн-ийг довтолсон, тэрхүү аян дайнд монгол ноёд холбоотон болж оролцсонтой холбоотойгоор Монголын тухай мэдээ 1627-1628, 1636-1638 онд харьцангуй нэмэгдсэн байна.

Түүнчлэн Манжийг эсэргүүцсэн монголчуудын бослого тэмцэл, тухайлбал Цахарын Бүрнi вангийн бослого, Галдан бошогтын үйл ажиллагаатай холбоотойгоор 1660-1670-аад он, 1680-90-ээд онд Монголын тухайт мэдээ харьцангуй их болж иржээ.

Түүнээс хойш Монголын талаарх мэдээ эрс багассан хэдий ч Ойрад-Манжийн тэмцэл тулаантай холбоотойгоор үе үе гарч ирж байна. Хамгийн сүүлчийн мэдээ 1790-ээд онд холбогдох бөгөөд тус мэдээнээс үзэхэд Чосөн улс монголчуудыг дахин хүчирхэгжинэ хэмээн үзэж, анхаарал хандуулж байжээ.


Хоёр. “Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл” дэх Монголын түүхэнд холбогдох мэдээ

XVI зууны эцсээр Цзяньчжоу-гийн Зүрчидийн нэгэн толгойлогч Нурхачи хүчирхэгжин зүрчидийн бусад аймгуудыг нэгтгэх, хөрш зэргэлдээх улсуудын талаар дайсагнасан бодлого явуулах болсноор Зүүн хойт Азийн түүхэнд ихээхэн өөрчлөлт гарсан юм. Чосөнчүүд шинээр хүчирхэгжин гарч ирсэн зүрчидийн аймгуудыг анхааралтайгаар ажиглаж, хоёр орны хооронд харилцаа тогтоохын хамтаар зүрчидийн талаар мэдээ мэдээлэл цуглуулж байсны нэг нь Шинь Чхүн-ил (신충일, 申忠一)-ийн тэмдэглэж үлдээсэн “Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл” (건주기정도기, 建州紀程圖記)⁴ билээ.

Энэхүү тэмдэглэлд 1596 онд Зүрчидэд элчээр одсон Шинь Чхүн-ил хэмээх түшмэл үзэж харсан зүйлээ тэмдэглэн үлдээсэн бөгөөд тэрхүү тэмдэглэл нь Хожуу Алтан улс байгуулагдахын өмнөх үеийн Зүрчидийн газар нутаг, уул ус, хот суурин, хүн ам, цэрэг арми, улс төр, зан заншил зэрэг олон талыг хамарсан нарийн мэдээллийг агуулдаг. Тэрээр

⁴ Шинь Чхүн-ил Цзяньчжоу-гийн зүрчидэд очоод ирснийхээ дараа 2 хувь илтгэх бичиг бичиж, нэгийг нь Чосөн-ий ванд өргөн бариад, нөгөөг нь өөртөө хадгалжээ. Ванд өргөн барьсан илтгэх бичиг нь “Чосөн улсын магад тэмдэглэл (조선왕조실록, 朝鮮王朝實錄) болон “Йөнгёнжэжёнъжиб (연경재전집, 研經齋全集)”-д хэвлэгджээ. Харин Шинь Чхүн-ил-ийн өөртөө хадгалсан эх нь түүний үр хойчист уламжлагдсаар эдүгээ хүрсэн ажээ.

Зүрчидэд байхдаа үзсэн харсан зүйлсээ 90 гаруй зүйлд хуваан тэмдэглэн үлдээсний дотор Монголтой холбоотой мэдээ баримт байдаг. Бидний олж үзсэнээр, эдгээр мэдээ баримтыг Монголын түүхч, судлаачдад хараахан танилцуулж амжаагүй бололтой.



“Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл”-ийн эх
(Эх сурвалж. <https://www.naver.com>)

“Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл”-ийн Монголтой холбоотой мэдээ нь хэмжээний хувьд тийм ч их бус. Ерөнхийдөө Шинь Чхүн-ил Нурхачийн хотод байхдаа уулзсан монголчууд, тэдэнтэй үг сольсон тухай, түүнчлэн монголчуудын ахуй байдал, зан заншил, газар нутгийн тухай мэдээнээс бүрдэнэ. Гэвч бусад түүхийн сурвалжид гардаггүй ховор сонин мэдээ баримт гарч байгаа нь тус тэмдэглэлийн үнэ цэнийг улам өргөж байна. Холбогдох мэдээг танилцуулбал дараах байдалтай ажээ.

Улаан бичин жил (1596)-ийн хаврын тэргүүн сарын шинийн 1-нд Нурхачийн өргөөнд найрлах үед “Монгол, Сахалча ... аймгийнхан хойт хананд суусан”⁵ гэжээ. Энд гарч буй монгол гэдэг нь Хорчин аймгийн ноёдыг хэлж байгаа бололтой. Үүнээс 3 жилийн өмнө буюу 1593 онд Хорчины ноён Унгадай, Мангус, Мянган нар зүрчидийн бусад аймагтай хамтран Нурхачитай байлдаад дарагдсаны дараа Хорчин, Өвөр Халх зэрэг аймгийн ноёд Нурхачид элч илгээн харилцах болсон билээ.⁶

“Нэгэн зүйл. Хөдлөхийн өмнө Монголын жанжин Ваньчжэ (晩者) лугаа дотоод хотын хаалга (內城門)-ны гадаа тааралдан, “Та нар энд удах уу?” хэмээн асуухад “Бид ч бас 7-нд буцна” хэмээн хариулсан ажээ.

Энд гарч буй Ваньчжэ (солонгос дуудлагаар Манъжа)-г Монголын ван Лаба (나팔, 刺八)-гийн дэд жанжин гэсэн тул Хорчин аймгийн нэгэн эзэн Мангусыг хэлж байгаа бололтой. Харин Лаба гэдэг нь Унгадайн хүү Ууба-г зааж байна хэмээн таамаглаж байна. Ууба нь 1593 онд эцгийгээ дагалдаж Нурхачитай хийсэн тулалдаанд оролцсон агаад “Монголын ван” гэснээс үзвэл 1596 он гэхэд эцгийнхээ суурийг залгамжлаад байсан бололтой. Шинь Чхүн-ил-ийн тэмдэглэлд 1593 оны тулалдаанд Монголын ван Лаба оролцсон гэжээ.

Шинь Чхүн-ил-ийн тэмдэглэлд монголчуудын эрхлэх аж ахуй, орон байр, хувцас хунарын талаар сонирхолтой мэдээ гарч байна. Үүнд:

“Нэгэн зүйл. Монголд тэргэн дээр гэрээ барьж, арьс ширээр майхан барих агаад гэдэс нь өлсвөл хуришсан мах (膾肉, борцыг хэлж буй бололтой-Ц.Ц.) идэж, ам нь цангавал үхэр, хонины сүү уудаг хэмээмүй”⁸.

Энд монголчууд тэргэн дээр гэрээ барьдаг тухай өгүүлсэн бөгөөд гэр тэрэгний тухай өгүүлсэн үү, эсвэл мухлаг тэрэгний тухай өгүүлсэн үү гэдэг нь тодорхойгүй аж. Хэрэв гэр тэрэгний тухай өгүүлсэн бол монгол гэр тэрэгний түүхийг нэлээд хойшлуулж, XVI зууны сүүлч хүртэл гэр

⁵ 蒙古，沙割者，忽可，果乙者，尼麻車，諸憊時，在北壁。

⁶ “Манжийн үнэн магад хууль”- д энэ тухай “Хөх морин жил (1594 он) умар зүгийн Монголын Хорчин улсын Мянган ноён, таван нутаг (отог) Халхын Лооса ноён элчээ явуулан үүсгэвэй. Түүнээс улам Монгол улсын аймаг бүрийн ноёдын элчид үргэлжид явлаа” хэмээн өгүүлжээ.

⁷ 發程時，逢蒙古將晩者于內城門外，問曰：“爾久在這裏否？”答曰：“俺亦初七日當還”云。

⁸ 一，蒙古，車上造家，以毳爲幕，飢則食膾肉，渴則飲酪漿云。

тэрэг хэрэглэж байсан хэрэг болох агаад шинжлэх ухаанд ихээхэн чухал баримт болно. Энэ талаар цаашид нарийвчлан судлах шаардлагатай байна.

“Нэгэн зүйл. Монголчууд бүгд арьсан хувцас өмссөн байлаа”⁹ хэмээн монголчуудын хувцас гоёлын тухай мэдээ байхаас гадна “Нэгэн зүйл. Монголд хавар цагт газар хагалах үед тал нутагт хүн, морь олноор цуглуулж, тэднээр олонтаа гишгэчүүлж, өтгө бууц хаяж, үржил шимтэй болгосны дараа шүлхий, бас шишийн олон төрлийг тарьж, бас дахин хүн, мориор гишгүүлээд, хогийн ургамлыг түүж, арчлах буюу ургац хураахдаа цэрэг эрсийг дайчилж туслуулдаг хэмээмүй”¹⁰ гэж монголчууд газар тариалан эрхлэхдээ ямар арга хэрэглэдэг, ямар зүйлийн үр тариа тарьдаг байсан талаарх ихээхэн сонирхолтой мэдээ гарч байна.

Түүнчлэн Монгол аймгуудын газарзүйн байрлалын талаарх мэдээ гарч байна. Тухайлбал: “Нурхачийн суудаг хотоос Монголын ван Лабагийн байх газар хүртэл зүүн хойт зүгт 1 сарын газар бөгөөд түүний дэд жанжин Ваньчжэ-гийн аймаг хүртэл 12 өдрийн зайтай”¹¹ гэсэн мэдээ гарч байна.

Монголын Хорчины ноёд 1593 онд Ехэ зэрэг аймгийн хамтаар Нурхачийн эсрэг тэмцээд ялагдсан тухай мэдээ нь “Манжийн үнэн магад хууль” зэрэг манж сурвалжийн мэдээтэй таарч байх агаад монголчуудын тухай нэлээд тодорхой мэдээ байх ажээ. Тухайлбал:

“Нурхачи олзлогдсон монголчуудаас 20 хүнийг шилж, торгон хувцас өмсгөн, байлдааны морь (зэвлэх морь) унуулж, нутаг руу нь илгээсэнд тэр 20 хүн эргэн очоод, Нурхачийн сүр алдрын талаар өгүүлжээ. Тиймээс Лаба өөрийн дэд жанжин Ваньчжэ тэргүүтэн 20 орчим хүнд 1 зуу гаруй бүдүүлгийг удирдуулж, байлдааны морь 100 толгой, тэмээ 10 толгойг өргөн барьсан агаад 60 морь, 6 тэмээг Нурхачид, 40 морь, 4 тэмээг Нурхачийн дүү Шурхачи-д өгөв. Тэрхүү жанжин, цэргүүдийг Нурхачи хүндлэн угтаж, торгон хувцас өгсөн хэмээмүй”¹² гэж тэмдэглэсэн нь

⁹ 一，蒙古，皆着毛皮衣。

¹⁰ 一，蒙古，春耕時，多聚人馬於平野，累累使之踐踏糞穢後，播黍粟、蜀秫諸種，又使人馬踐踏。至耘治、收穫時，令軍人齊力云。

¹¹ 自老酋城至蒙古，蒙古王刺八所在處，東北距一月程，次將晚者部落，十二日程。

¹² 奴酋選所獲蒙古人二十，被錦衣，騎戰馬，使還其巢穴，二十人歸言，奴酋威德，故刺八令次將晚者等二十餘名，率胡百餘人，持戰馬百疋、橐駝十頭來獻。馬六十疋、駝六頭，與奴酋；馬四十疋、駝四頭，與小酋；其將領等，奴酋皆厚待，給與錦衣云。

Хорчин аймаг Нурхачитай харилцаа тогтоосон талаар илүү тодорхой мэдээллийг агуулсан, бусад сурвалжид гардаггүй өгүүлэл билээ.

Түүнчлэн “Олон бүдүүлгүүдийн дундаас Монгол, Ехэ, Ула зэрэг нь хамгийн хүчирхэг хэмээмүй”¹³ гэж Зүрчидийн хөрш зэргэлдээх хүчирхэг аймаг улсын тоонд Монгол багтдаг тухай өгүүлжээ.

Бүхэлд нь авч үзвэл, “Цзяньчжоу-гийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл” дэх Монголын түүхэнд холбогдох мэдээ нь тийм ч их бус боловч, дээрх мэдээнүүдээс Монголын түүхийн зарим нэг асуудлыг тодруулах боломжтой юм.

Тус тэмдэглэлийн мэдээ занги нь Манжийн түүхийн сурвалжийн мэдээтэй таардаг тул тус тэмдэглэл дэх Монголтой холбоотой мэдээ нь ч бас бодит үнэнд ойр гэдэг нь илэрхий. Гэвч зарим мэдээг нь ойролцоо үед бичигдсэн Сяо Дахэн (蕭大亨)-гийн Түмэд монголчуудын тухай “Монголын зан суртахууны тэмдэглэл” (夷俗記)-тэй харьцуулан үзвэл илүү тодорхой болно. Тухайлбал, монголчуудын газар тариалан, хувцас хунарын талаар Сяо Дахэн-гийн тэмдэглэлтэй харьцуулан үзэх боломжтой.

Сяо Дахэн ч бас монголчууд газар тариалан ихээр тариалдаг тухай өгүүлсэн бөгөөд Шинь Чхүн-ил-ийн тэмдэглэлд тариалах ажлын тухай илүү тодорхой тэмдэглэжээ.

Харин монголчууд арьсан хувцас өмссөн байсан тухай тэмдэглэсэн нь тухайн үед өвлийн сүүл, хаврын эхэн байсан тул үстэй дээл хувцас өмссөн байсныг хэлсэн бололтой. Сяо Дахэнгийн тэмдэглэлд ч монголчууд дээл хувцсаа арьсаар хийдэг, харин сүүлийн үед торго хэмэрлигээр үйлдэх болсон гэжээ.

Энэ бүхнээс үзэхэд, Шинь Чхүн-ил-ийн тэмдэглэл нь үнэн бодитой бөгөөд Манжтай анх харилцаж эхэлсэн Монголын зүүн хойт зүгийн Хорчин зэрэг олон аймгуудын түүх, соёл, зан заншил, аж ахуйн талаар бусад сурвалжид гардаггүй, сонирхолтой мэдээллийг агуулж байна.

Төгсгөл

“Чосөнъ улсын магад тэмдэглэл” тэргүүтэй солонгос сурвалжид монголчуудтай холбоотой хэдэн зуун мэдээ гарч байгааг бид олж тогтоов. Тэдний дотор Монголын улс төрийн байдал, Монгол-Солонгосын харилцаа, Монгол-Мин улс болон Монгол-Манжийн харилцаа, Монголын соёлтой холбоотой мэдээ зонхилох хувийг эзэлж

¹³ 諸胡中，蒙古、如許、兀刺等最强云。

байна. Бид зарим мэдээг нанхиад, манж, монгол сурвалжтай харьцуулж үзэхэд үнэн бодтой мэдээ мэдээлэл болох нь батлагдав.

Солонгосын түүхийн сурвалжийн мэдээ зангийн гол онцлог бол тухайн үеийн Монголын түүх, ялангуяа Монгол-Мин улс, Монгол-Манж Чин улсын харилцааны түүхэнд холбогдох үйл явдлуудыг гуравдагч этгээдийн байр сууринаас харж, тэдгээр үйл явцын байдал, цаашдын дэлгэрэлтэд үнэлэлт дүгнэлт өгөхийг оролдсон явдал юм.

Чосөнъ-ий сурвалж бичигт гарч буй монголчуудын талаарх ерөнхий төсөөлөл нь “хүчирхэг Монгол” бөгөөд чосөнъчүүд анхандаа Монголыг Мин улстай Зүүн Азид ноёрхохын төлөө эн тэнцүү өрсөлдөх улс гэж үзэж, тэдний үйл ажиллагааг нүд салгалгүй ажиглаж байжээ.

Тухайн үеийн түүхэн эх хэрэглэгдэхүүний нэг болох “Цзяньчжоугийн зүрчидэд аялсан зурагт тэмдэглэл” дэх Монголын түүхэнд холбогдох мэдээ нь тийм ч их бус боловч, дээрх мэдээнүүдээс Монголын түүхийн зарим нэг асуудлыг тодруулах боломжтой юм.

Цаашид солонгос сурвалж дахь хамаа бүхий мэдээг олж илрүүлэх, судлах, судалгааны эргэлтэд оруулах нь дундад үеийн Монголын түүхийг судлахад зохих тус дэм болно гэж үзэж байна.

Ном зүй

Монгол хэлээр

Зарлигаар тогтоосон гадаад монгол, хотон аймгийн ван гүнгүүдийн илтгэл шастир (1-44-р дэвтэр). Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, тайлбар хийсэн Ц.Цэрэндорж, Л.Эрдэнэболд, Д.Баржав, Н.Ганбат. Манж, хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж. УБ. 2007.

Манжийн үнэн магад хууль. Монгол бичгээс кирилл бичигт буулгаж, манж, хятад эхтэй харгуулсан Ц.Цэрэндорж. УБ. 2009.

Ц.Цэрэндорж. *Монголын Тайсун хаанаас 1442 онд Чосөнъ улсын Сэжон ванд илгээсэн сургах зарлигийн бичиг* // Түүхийн судлал. №40, УБ. 2010. 355-362-р тал.

Ц.Цэрэндорж. *Манжийн эрхшээлийн үеийн Монголын түүхэнд холбогдох солонгос сурвалжийн зарим мэдээ* // CNEAS Reports 13, Чин улс ба монголчууд, Япон, Сэндай. 2014. 247-266-р тал.

Ц.Цэрэндорж. *Солонгосын түүхийн сурвалж дахь XIV-XVIII зууны үеийн Монголтой холбоотой мэдээ баримт* // Солонгос судлал сэтгүүл, 1 (5). 2018. 10-26-р тал.

Ц.Цэрэндорж. *Солонгосын түүхийн сурвалж дахь XIV-XVIII зууны үеийн монголтой холбоотой мэдээ баримт* (“Чосонъ улсын магад тэмдэглэл”-ийн жишээн дээр) // Түүхийн судлал. №48, УБ. 2019. 92-104-р тал.

Солонгос, япон хэлээр

朝鮮王朝實錄 (<http://sillok.history.go.kr>)

송미령, 「17-18세기 조선 정부의 몽골 이해」, 『중국사연구』, 第62輯, 2009, 137-167쪽.

오종록, 「朝鮮初期의 國防觀」, 『진단학보』 86, 진단학회 1998, 137-155쪽.

우인수, 「17세기 후반 대만 정씨 해상세력에 대한 조선의 정보수집과 그 의미」, 『대구사학』, 第100輯, 2010, 163-187쪽.

Ts. 체렌도르지, 「몽골제국 시대 이후 몽골이 아시아의 역사에 끼친 영향에 대하여」, 『아시아문화연구』, 가천대학교 아시아문화연구소, Vol. 41, 2016, 99-124쪽.

홍성구, 「“朝鮮王朝實錄”에 비친 17세기 내륙아시아 정세와 ‘寧古塔回歸說’」, 『中國史研究』, 第69輯, 2010, 274-307쪽.

伍躍, 「朝貢關係と情報收集-朝鮮王朝對中國外交を考える際して」, 『中國東アジア外交交流史の研究』, 夫馬進編, 京都大學學術出版會, 2007.